

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эко хотын тээвэр ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/018/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: <a href="mailto:boldch@audit.gov.mn">boldch@audit.gov.mn</a></p> <p>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarda@audit.gov.mn">otgonbayarda@audit.gov.mn</a></p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа Утас: 99108763, Цахим хаяг: <a href="mailto:uwaauul.audit@gmail.com">uwaauul.audit@gmail.com</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

᠒᠐25.03.14 № 01/᠒82  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭКО ХОТЫН ТЭЭВЭР  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРЛЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ХАВСРАН  
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЭРДЭНЭЧИМЭГ  
ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хан уул дүүргийн Эко хотын тээвэр ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 322,821.2 мянган төгрөгийн залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг, "нийцсэн бөгөөд зохистой байх", "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын даргын 2023 онд баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн II.2.1.3 дахь хэсэгт Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандартыг мөрдөж, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу санхүүгийн тайлан гаргахаар тусгасан боловч төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн загвараар бэлтгэсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөл эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг оны эхэнд батлаагүй, сар бүр төлөвлөгөө, зардлыг баталсан байна.

## **Бусад асуудал**

Хан-Уул дүүргийн хариуцсан бүсийн 6 хороонд 11631 удаагийн рейсээр 43072 тонн хог хаягдал тээвэрлэн, нийтийн эзэмшлийн 290290 м.кв талбайн цэвэрлэгээ үйлчилгээг гүйцэтгэж, 58126 м.кв талбайд шарилж устгалыг хийсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,797,438.60</b>	<b>986,279,948.16</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,107,228.96</b>	<b>735,032,457.96</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1,107,228.96</b>	<b>735,032,457.96</b>
3121	Төгрөг	1,107,228.96	735,032,457.96
31213	Арилжааны банк дахь харилцах	1,107,228.96	735,032,457.96
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>8,751,407.64</b>	<b>17,284,808.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	777,308.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	7,475,000.00	-
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	1,276,407.64	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	<b>16,507,500.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	-	6,407,500.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	10,100,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>2,938,802.00</b>	<b>29,319,682.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>2,938,802.00</b>	<b>29,319,682.00</b>
35410	Бичиг хэргийн материал	-	610,500.00
35420	Аж ахуйн материал	-	4,049,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	2,623,500.00
35440	Түлш, шатах тослох материал	2,938,802.00	14,168,282.00
35470	Бусад хангамжийн материал	-	7,868,400.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	<b>204,643,000.20</b>
36600	Бусад нөөц	-	194,737,900.20
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	-	9,905,100.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,008,366,970.90</b>	<b>3,164,475,397.75</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,008,366,970.90</b>	<b>3,164,475,397.75</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,005,992,970.90</b>	<b>3,162,366,897.75</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	16,940,330.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(462,466.59)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,271,848,500.00	3,780,408,566.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(393,904,708.26)	(1,004,172,080.27)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	101,475,890.00	388,539,860.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,114,055.84)	(59,601,530.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,212,800.00	48,283,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,525,455.00)	(7,569,281.51)
393	Биет бус хөрөнгө	2,374,000.00	2,108,500.00
39301	Програм хангамж	2,655,000.00	2,655,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(281,000.00)	(546,500.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,021,164,409.50</b>	<b>4,150,755,345.91</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,906,871.13</b>	<b>1,355,199,324.91</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,906,871.13</b>	<b>1,355,199,324.91</b>
413	Өглөг	7,906,871.13	60,191,455.38
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,966,271.13	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,940,600.00	-
4136	Бусад өглөг	-	60,191,455.38
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	60,191,455.38
414	Урьдчилж орсон орлого	-	1,295,007,869.53
41440	Бусад урьдчилж орсон орлого	-	1,295,007,869.53
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,013,257,538.37</b>	<b>2,795,556,021.00</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,013,257,538.37	2,795,556,021.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,013,257,538.37	2,795,556,021.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,305,516,882.39	2,013,257,538.37
51220	Тайлант үеийн үр дүн	707,740,655.98	782,298,482.63
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,021,164,409.50</b>	<b>4,150,755,345.91</b>

## 2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,938,417,260.51</b>	<b>7,092,161,709.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,103,507,030.51</b>	<b>365,823,087.10</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,103,507,030.51</b>	<b>365,823,087.10</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	134,740,000.00	126,601,518.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	134,740,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	126,601,518.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	2,775,102.51	3,038,249.65
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	955,400,000.00	102,888,729.25
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	10,591,928.00	133,294,590.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,834,910,230.00</b>	<b>6,726,338,622.40</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
1330	Төсвийн захирагчдаас	1,834,910,230.00	6,726,338,622.40
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	1,834,910,230.00	6,726,338,622.40
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,230,676,604.53</b>	<b>6,309,863,226.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,230,676,604.53</b>	<b>6,307,663,226.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,228,876,604.53</b>	<b>6,292,557,399.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,104,209,685.54</b>	<b>3,282,645,026.01</b>
210101	Үндсэн цалин	951,367,257.78	3,275,666,026.01
210102	Нэмэгдэл	16,060,927.76	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	136,781,500.00	-
210104	Урамшуулал	-	6,979,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>156,492,225.00</b>	<b>421,295,437.79</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	156,492,225.00	421,295,437.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>107,700,000.00</b>	<b>184,860,806.00</b>
210304	Байрны түрээс	107,700,000.00	184,860,806.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>478,436,862.29</b>	<b>1,242,585,183.66</b>
210401	Бичиг хэрэг	2,052,180.00	7,678,939.00
210402	Тээвэр, шатахуун	466,047,779.29	1,090,571,348.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,949,552.00	1,431,268.66
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	109,291,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,387,351.00	33,612,628.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>99,938,254.00</b>	<b>358,999,215.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,737,904.00	154,821,463.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	54,200,350.00	204,177,752.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,542,600.00</b>	<b>26,920,680.00</b>
210701	Гадаад албан томилолт	8,542,600.00	9,416,980.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	17,503,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>55,780,635.00</b>	<b>119,871,951.43</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,240,000.00	30,359,378.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	4,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,847,175.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,693,460.00	427,467.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	264,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	14,869,946.80
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	649,874.95
210813	Бусад зардал /ТӨҮГ/	-	1,492,060.00

210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	-	61,450,981.68
210816	Татварын байгууллагад төлсөн - ТӨҮГ		359,238.00
210817	Даатгалын төлбөрт төлсөн - ТӨҮГ		5,499,005.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>217,776,342.70</b>	<b>655,379,099.93</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	227,837,928.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	217,776,342.70	427,541,171.93
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,800,000.00</b>	<b>15,105,827.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,800,000.00</b>	<b>15,105,827.05</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	11,705,827.05
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	3,400,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>2,200,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,200,000.00
223001	Бусад хөрөнгө	-	2,200,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>707,740,655.98</b>	<b>782,298,482.63</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>707,740,655.98</b>	<b>782,298,482.63</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
1	<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	<b>1,305,516,882.39</b>	<b>1,305,516,882.39</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
4	Тайлант үеийн үр дүн	-	707,740,655.98	707,740,655.98
9	<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	<b>2,013,257,538.37</b>	<b>2,013,257,538.37</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-
12	Тайлант үеийн үр дүн	-	782,298,482.63	782,298,482.63
17	<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	<b>2,795,556,021.00</b>	<b>2,795,556,021.00</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,972,425,332.51</b>	<b>6,852,940,140.40</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>137,515,102.51</b>	<b>126,601,518.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>137,515,102.51</b>	<b>126,601,518.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	134,740,000.00	126,601,518.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	134,740,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	126,601,518.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	2,495,102.51	-
120015	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/	280,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,834,910,230.00</b>	<b>6,726,338,622.40</b>
1330	Төсвийн захирагчдаас	1,834,910,230.00	6,726,338,622.40
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	1,834,910,230.00	6,726,338,622.40
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,997,587,961.72</b>	<b>5,936,300,161.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,997,587,961.72</b>	<b>5,936,300,161.05</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,997,587,961.72</b>	<b>5,919,683,057.45</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	892,478,678.47	2,689,175,144.22
210101	Үндсэн цалин	892,478,678.47	2,460,142,852.22
210104	Урамшуулал	-	6,979,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	39,000,000.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	-	183,053,292.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>280,103,522.19</b>	<b>774,518,766.04</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	280,103,522.19	774,518,766.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,629,464.93	186,483,306.00
210304	Байрны түрээс	-	186,483,306.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	9,629,464.93	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>509,846,298.00</b>	<b>901,878,011.14</b>
210401	Бичиг хэрэг	-	6,800,400.00
210402	Тээвэр, шатахуун	442,889,417.00	615,362,195.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,855,170.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	165,790,054.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	57,355,961.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	24,933,731.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	66,956,881.00	27,780,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>333,668,931.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	140,110,857.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	181,163,624.00
210604	Урсгал засвар	-	12,394,450.00
2107	Томилолт, зочны зардал	-	9,416,980.00
210701	Гадаад албан томилолт	-	9,416,980.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>305,529,998.13</b>	<b>870,671,019.05</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	568,889,941.32
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	4,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	427,467.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	1,430,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	9,112,618.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	649,874.95

210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	94,243,453.75	280,161,212.78
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	1,847,175.00	5,499,005.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	209,439,369.38	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>153,870,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	153,870,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	16,617,103.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,617,103.60
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	7,532,836.93
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	9,084,266.67
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(25,162,629.21)</b>	<b>916,639,979.35</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>70,248,610.00</b>	<b>185,753,000.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	70,248,610.00	185,753,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	70,248,610.00	185,753,000.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	-	185,753,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	70,248,610.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(70,248,610.00)</b>	<b>(185,753,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(95,411,239.21)</b>	<b>730,886,979.35</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>96,518,468.17</b>	<b>1,107,228.96</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,107,228.96</b>	<b>735,032,457.96</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>6,855,978,389.63</b>	<b>6,855,978,389.63</b>	-	<b>100.0</b>
<b>Төсвөөс урсгал санхүүжилт</b>	<b>6,726,338,622.40</b>	<b>6,726,338,622.40</b>	-	<b>100.0</b>
Туслах үйл ажиллагааны орлого	126,601,518.00	126,601,518.00	-	100.0
Бусад орлого /Банкны хүүгийн орлого, ... /	3,038,249.23	3,038,249.23	-	100.0
НИЙТ ЗАРДАЛ БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,855,611,280.00	6,122,053,161.06	733,558,118.94	89.3
<b>21 УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,845,811,280.00</b>	<b>6,112,968,894.39</b>	<b>732,842,385.61</b>	<b>89.3</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,580,578,666.00</b>	<b>2,977,309,193.34</b>	<b>603,269,472.66</b>	<b>83.2</b>
Үндсэн цалин, нэмэгдэл, хоол унаа	3,580,578,666.00	2,977,309,193.34	603,269,472.66	83.2
<b>Нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>818,537,809.00</b>	<b>774,518,766.04</b>	<b>44,019,042.96</b>	<b>94.6</b>
Байр ашиглалттай холбоотой зардал	191,280,000.00	186,483,306.00	4,796,694.00	97.5
Байрны түрээс	191,280,000.00	186,483,306.00	4,796,694.00	97.5
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,384,872,500.00</b>	<b>1,348,617,660.74</b>	<b>36,254,839.26</b>	<b>97.4</b>
Бичиг хэрэг	7,600,000.00	6,800,400.40	799,599.60	89.5
Тээвэр, шатахуун-Түлш	640,000,000.00	615,362,195.00	24,637,805.00	96.2
Тээвэр, шатахуун-Машин түрээс	454,500,000.00	447,361,149.00	7,138,851.00	98.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,020,000.00	3,855,170.14	164,829.86	95.9
Хог хаягдал зайлуулах ариутгал-Давс, бодис, Хогын цэг ариутгал	166,952,500.00	165,790,054.00	1,162,446.00	99.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	57,400,000.00	56,734,461.00	665,539.00	98.8
Аж ахуйн материал худалдан авах зардал	54,400,000.00	52,714,231.20	1,685,768.80	96.9
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>537,919,667.00</b>	<b>514,643,431.00</b>	<b>23,276,236.00</b>	<b>95.7</b>
Багаж, техник, хэрэгсэл	154,470,000.00	145,610,857.00	8,859,143.00	94.3
Үндсэн хөрөнгө	169,273,000.00	167,884,170.00	1,388,830.00	99.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	193,776,667.00	181,163,624.00	12,613,043.00	93.5
Урсгал засвар-ТҮ	20,400,000.00	19,984,780.00	415,220.00	98.0
Томилолт, зочны зардал	10,000,000.00	9,416,980.00	583,020.00	94.2
Гадаад албан томилолт	10,000,000.00	9,416,980.00	583,020.00	94.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	166,021,120.00	148,108,657.27	17,912,462.73	89.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	148,371,120.00	131,428,792.32	16,942,327.68	88.6
Даатгалын үйлчилгээ	6,000,000.00	5,499,005.00	500,995.00	91.7
Тээврийн хэрэгслийн татвар	1,900,000.00	1,858,367.00	41,633.00	97.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,000,000.00	8,672,618.00	327,382.00	96.4
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	649,874.95	100,125.05	86.6
<b>Бараа үйлчилгээний бусад</b>	<b>156,601,518.00</b>	<b>153,870,900.00</b>	<b>2,730,618.00</b>	<b>98.3</b>

<b>зардал</b>				
Бараа үйлчилгээний бусад зардал	156,601,518.00	153,870,900.00	2,730,618.00	98.3
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,800,000.00</b>	<b>9,084,266.67</b>	<b>715,733.33</b>	<b>92.7</b>
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	9,800,000.00	9,084,266.67	715,733.33	92.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,800,000.00	9,084,266.67	715,733.33	92.7
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл /2024.01.01/		1,107,228.96		
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл /2024.12.31/		735,032,457.43		

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 290,500.0 мянган төгрөгийн алдаа<sup>[1]</sup> илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Үндсэн хөрөнгийн 290,500.0 мянган төгрөгийн орлогыг бөөн дүнгээр бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу залруулга хийлгэж санхүүгийн тайланг баталгаажуулав.

Аудитаар нийт 747,073.4 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч 4 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 747,073.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 22,306.8 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/	
							Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн орлогыг бөөн дүнгээр бүртгэсэн.	1	290,500.0			1	290,500.0	1	290,500.0
<b>Дүн</b>	<b>1.0</b>	<b>290,500.0</b>	-	-	<b>1.0</b>	<b>290,500.0</b>	<b>1.0</b>	<b>290,500.0</b>

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



Байгууллагын хөрөнгөөр хүлээн авалтын арга хэмжээ зохион байгуулж зардал гаргасан.	1	16,051.2	1	16,051.2				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>16,051.2</b>	<b>1</b>	<b>16,051.2</b>				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төсвийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй.	1	27,421.5					1	27,421.5
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>27,421.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>27,421.5</b>
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>43,472.7</b>	<b>1</b>	<b>16,051.2</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>27,421.5</b>